48 102

# УЛААНБААТАР
## ХОТЫН ХӨДӨЛМӨРЧДИЙН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
## ШИЙДВЭР

Улаанбаатар

1955 оны 10 дугаар сарын 10 Дугаар 184 Хот

Орон сууцны захиргаадын дүрмийг батлах тухай.

Хотын Хөдөлмөрчдийн Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргааны Гишүүдийн Хуралдаанаас Т О Г Т О О Х нь:

1. Хотын орон сууц-нийгэмийн хангамжийн аж ахуйг удирдах газрын харьяа орон сууцны захиргаадын дүрмийг баталсугай.

2. Орон сууцны захиргаадын дүрмийг практик ажил дээр нь хангаж биелүүлэхийг орон сууцны захиргаадын дарга нарт даалгасугай.

3. Орон сууцны захиргаадаас Сайд нарын Зөвлөлийн 1955 оны 299 -р тогтоолоор батлагдсан сууц ашиглалтын тухай дүрэм ба энэ дүрмийн биелэлтэд үргэлжийн хяналт тавьж байхыг хотын орон сууц-нийгэмийн аж ахуйнуудыг удирдах газарт үүрэг болгосугай.

Хотын Хөдөлмөрчдийн Д:Х.Г .
Захиргааны дарга //Б А Г А А//
Хариуцлагатай нарийн бичгийн дарга //Д А М Д И Н//

Нохив От. Нийлэв.......

Хотын Х.Т.Х.Г.Захиргааны 1955 оны 9-р сарын .. ны өдрийн .... р хуралдаанаар батлав.

## Орон сууцны захиргааны дотоод дүрэм.

### Орон сууцны захиргааны үүрэг.

1. Хотын орон сууц, нийгэмийн хангамжийн аж ахуйн хүрээлэнг удирдах газар, орон сууцны хэлтэст шууд захирагдаж өөр цутам практик ажил дээр удирдлага авч аж ахуйн тооцоон дээр ажиллана.

2. Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн 1955 оны 7-р сарын 16-ны өдрийн 299-р тогтоол, орон сууцны ашиглалтын тухай дүрмийг удирдлага болгож ажиллах ба түүний биелэлтийг шууд хариуцана.

3. Хотын Х.Д.У.Гүйцэтгэх захиргааны даргуудын хуралдааны 1955 оны 3-р сарын 17-ны 17, мөн 8-р сарын 3-ны 110, 9-р сарын 9-ний 139-р шийдвэрүүдийг практик дээр чанд биелүүлэх ажлыг хариуцана.

4. Орон сууц хүсэлтэн авагчид хотын гүйцэтгэх захиргаанаас олгогдсон ордерийг баримтлаж сууцны тухай мэдээ хүлээлгэн өгч байж ба сууц ашиглалтын гэрээг 7 хоногийн дотор батлаж байгуулна.

5. Орон сууцны байшинг ашиглах ба арчлах тухай дүрэмд заасан капитал засваруудыг цаг тухайд нь өөрийн хөрөнгө хүчээр хийж гүйцэтгэнэ.

6. Улсын орон сууцны фондыг эвдрэлээс сэргийлэн хамгаалах бүх арга хэмжээг урьдчилан авч байна.

7. Орон сууц, ашиглагчдын хэнгэн гавлгай үйлчлэх ба тэд нарын эрэлт хүсэлт санал гомдлыг барагдуулах зорилгоор 3 хоногийн дотор бүтээж арга хэмжээ авч хариу мэдэгдэж байна.

8. Орон сууцны байшин байрны урсгал /хөнгөн/ засваруудыг дүрмийн 10-р зүйлд заасанаар суугчдын вардан хүчээр хийлгэж байрны ахлагч ба олон нийтийн комиссын оролцоотойгоор уг засварыг тусгай актайгаар хүлээлгэн авна.

9. Байр ашиглалтын тооцоог үнэн зөвөөр бодож нэхэмжлэлийг сар бүрийн 25-ны дотор сууц ашиглагч нарт гардуулан өгч дараа сарын 5-ны дотор хөлс хураан авсан тухай тодорхойлолтод тэмдэглэсэн байна.

10. Сууц ашиглагчдын дунд байрны журам сахиулаж байр сууцыг боловсоноор ашиглуулаж байна.

11. Байруудыг цэвэр боловсон байлгах нийтийн ашиглалтанд байдаг зохих хашаа, бие засах газар, пин, түлээний саравч бохир усны нүх, шат, хаалгыг бүрэн бүтэн хэвийн ашиглагаатай байлгана.

12. Нэгдсэн байруудад суугчдын зөвлөлгөөнийг улирал нэгээс доошгүй хийлгэж, сууц ашиглагчдын санал зөвлөлгөөнийг сонсож түүнтэй өөрийн ажлыг холбож явуулах, мөн байрны ахлагч олон нийтийн комиссуудыг жилээс доошгүй хугацаагаар сонгон байгуулж орон сууцны захиргааны ажилд туслалцуулна.

3. Байрны ахлагчийн үүрэг.

1. Байрны ахлагч нь орон сууцны захиргааны төлөөлөгч нь болоод орон сууцны захиргаанаас үүргийг хүлээн авах ба түүний ажлыг биечлэн туслах дүрэм ба гэрээгээр сууц ашиглагчдын хүлээсэн үүргүүдийн биелэлтэнд хяналт шалгалт тавьж байна.

2. Байрыг боловсон цэвэр байлгах гамтай ашиглах, дүрэм ба

гэрээнд заасан үүргийг биелүүлэх талаар сууц ашиглагчдад шаардлага тавих.

3. Байр ашиглагчдын санал хүсэлтийг хүлээн авч захиргаа-дад уламжлах.

4. Орон сууцны хашаа байруудыг засварлах, мод тарималт, цэцэрлэгжүүлэх, түүнийг арчлах, хүүхдийн тоглоомын талбай, байгуулах , ажилд суугчдын хүчийг зохион байгуулж оролцуулах.

5. Байранд суугчдын дотор халдварт өвчин гарвал орон сууцны захиргаа ба эмнэлгийн байгууллагад мэдэгдэх.

6. Ирсэн явсан хүмүүсийг цаг тухайд нь бүртгэж байх ба байр суларсанг орон сууцны захиргаанд мэдэгдэх.

7. Орон сууцны захиргаа сууц ашиглагч нарын хоорондын тооцооны асуудалд хяналт тавьж шаардлагатай үед тооцоог орон сууцны захиргааны шийдвэрээр ба байр ашиглагчийн хүсэлтээр орон сууцны захиргаа, сууц ашиглагчдын хооронд хийж байгаа тооцоог нягтлах [illegible].

8. Орон сууцны захиргаанд нь өөртөө тусгай тэмдэгтэй байх ба Б.Н.М.А.Улсын банкинд харилцах данс нээж сарын тайлан, улирлын баланс гаргаж байна.